

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Оршил	3
Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....	4
1.1 Тайлангийн нэр.....	4
1.2 Төслийн зорилго.....	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	4
1.4 Төслийн байршил.....	4
1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл.....	5
1.6 Ордын элсний нөөц.....	5
1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.8 Төслийн хүчин чадал.....	6
1.9 Ил уурхайн ашиглалтын технологи.....	6
1.10 Зам харилцаа.....	6
1.11 Дулаан хангамж.....	6
Бүлэг 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл.....	7
2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	7
2.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	8
2.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	8
2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 10	
2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
2.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	11
2.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
2.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	13
2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	14
2.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	16
Дүгнэлт.....	17
Ашигласан материал.....	18
Хавсралтын жагсаалт.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбилцол.....	4
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийн хүснэгт	7

Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл.....	8
Хүснэгт 5. Мод тарьсан газрын солбицол.....	9
Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	11
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл	13
Хүснэгт 8. ОХШХ-ийн гүйцэтгэл	14
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл	14
Хүснэгт 10. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний гүйцэтгэл	16
Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийн нийт зардал.....	17

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг	5
Зураг 2. Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн зураг	8
Зураг 3. Уурхайн усны сав	8
Зураг 4. Нүри ХХК-ий тайлангийн зураг.....	10
Зураг 5. Гал унтраах хэрэгслийн зураг	12
Зураг 6. Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг	12
Зураг 7. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан зураг	15
Зураг 8. Ажилчид эмчийн үзлэгт хамрагдаж байгаа үеийн зураг	15
Зураг 9. Ажилчдыг ХАБ-ын сургалтад хамруулсан үеийн зураг.....	16

ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан /гол болон сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт/, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт зэргээс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь албан ёсны баримт бичиг бөгөөд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн товч тодорхойлолт бөгөөд жил бүрийн байгаль орчны биелэлтийг хянан үзэж, батлуулж байх шаардлагатай.

БОМТБТ –гийн зорилго: “Мөнх сонор трейд” ХХК –ийн элсний ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай ажлыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд тайлагнахад оршино.

“Зүүн элстэй” элсний орд нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагааны бүхий л үе шат бүрт байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Мөнхсонор трейд” ХХК-ний авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дагуу боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж боловсруулж, холбогдох материалуудыг хавсаргалаа.

“Зүүн элстэй” элсний ордын БОМТ-нд 2024 онд нийт 13.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

“Мөнх сонор трейд” ХХК нь 2024 онд элсний гарц муу байсан учир 7 хоногийн хугацаанд ажилласан бөгөөд ингэхдээ “Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн уурхайн ажилчид болон техник, тоног төхөөрөмжүүдийг авч ажиллуусан болно.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Тайлангийн нэр

“Зүүн элстэй” нэртэй элсний ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

1.2 Төслийн зорилго

“Зүүн элстэй” элсний ордын элсийг олборлож сайн чанарын элс зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Мөнхсонор трейд” ХХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар		9011558143
3	Ордын нэр		Зүүн элстэй
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар
5		Сум/Дүүрэг	Налайх
6	Ашигт малтмалын төрөл		Элс
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		18/М013 (MV-11000095)
8	Ашиглалт эхэлсэн огноо		2024
9		Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Баянгол
11	Аж ахуйн нэгжийн хаяг	Баг/Хороо	22-р
12		Гудамж/Байр	Зүүн наран 15, 1036 тоот
13		Утас	99685498
14	Захирлын хаяг	Нэр	Э. Гантуяа
15		Утас	91915431

1.4 Төслийн байршил

“Зүүн элстэй” нэртэй элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг. Улаанбаатар хотын төвөөс 60км, Налайх дүүргийн хотын төвөөс 15км Элстэйн элсний ордтой зэргэлдээ оршино.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	107	30	1.48	47	46	40.4
2	107	30	1.48	47	46	47.86
3	107	30	25.95	47	46	47.86
4	107	30	25.95	47	47	1.68
5	107	31	30.2	47	47	1.68
6	107	31	30.2	47	46	40.4



Зураг 1.Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

1.5 Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн элстэй” нэртэй 99.65 га талбай бүхий ашигт малтмалын 18/М013 (MV-11000095) дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр “Мөнх сонор трейд” ХХК-д олгосон байна.

Техник, эдийн засгийн үндэслэлд “Мөнх сонор трейд” ХХК-ийн захиалгаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн элстэй” нэртэй элсний ордыг 22 жилийн хугацаанд, жилийн 50.0 мян.м³ элс олборлох хүчин чадалтайгаар ТЭЗҮ-д боловсруулагдсан байна.

1.6 Ордын элсний нөөц

“Мөнхсонор трейд” ХХК нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт Зүүн элстэй ордод эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж, улмаар 2017 оны 03 дугаар сарын 30 –ны өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Уул Уурхайн Яам, Ашигт Малтмалын Газрын дэргэдэх Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитой В зэрэглэлийн 1,146.36 мян.м³ элсний нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

1.7 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, үйлдвэрлэлийн нөөц

“Зүүн элстэй” элсний ордын ойролцоох бусад элсний уурхайнуудын ашиглалт явуулж байгаа болон одоогийн ашиглалтын байдлаас дүгнэж үзэхэд элсийг олборлох явцад ашиглалтын хаягдал, бохирдлын хэмжээг бага байлгах боломжтой байна. Иймд хаягдал, бохирдлыг дараах байдлаар тооцлоо.

Элсний хаягдал:

Давхаргын ул, таазнаас хаягдал гэж тооцлоо. Иймд элсний нөөц бодогдсон блокийн талбай тус бүр дээр ул, таазнаас 0.1 м зузаантай элсийг хөрстэй хамт хуулна. Үүнд хаягдах элсний хаягдлыг блок тус бүрээр нь тооцсон. Хаягдлын хувьд дунджаар 6.79% буюу 78.78 мян.м³ элс хаягдахаар байна.

Элсний бохирдолт:

Ашиглалтын хугацаанд ил уурхайн хоёр хажуугаас бохирдол гарна. Бохирдолтын хувьд дунджаар 0.55% буюу 6.42 мян.м³ байна.

1.8 Төслийн хүчин чадал

Ил уурхай нь жил бүр 50.0 мян.м³ элс олборлох ба 22 жил ажиллахаар байна.

1.9 Ил уурхайн ашиглалтын технологи

Уул-техникийн нөхцөл: Орд газар нь уул техникийн харьцангуй энгийн нөхцөлд оршдог. Хөрсний дундаж зузаан 0.23 м, элсний дундаж зузаан 2.76 м байна. Уул-техникийн нөхцөлийн хувьд хөрсний ус, хөлдөлт зэрэг аливаа хүндрэлгүй. Ордын элс, хөрсний зузаан, дундаж агуулга блокын урт, өргөн зэрэг үндсэн үзүүлэлтүүд нь харьцангуй жигд тогтвортой үргэлжилдэг уурхайн олборлолт, ашиглалтын явцад ямар нэг хүндрэл байхгүй үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангах сайн талтай.

Ашиглалтын систем: Ордыг ил аргаар ашиглах ба элсний тогтоц, хөрсний зузаан, газар зүйн байрлал, хөрсний чулуулгийн шинж чанар зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр тус ордыг гадаад болон дотоод овоолготой авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар сонгосон байна.

Уурхайн нээлт: Ордын уул-техникийн нөхцөл нь уурхайн нээлтийг аль ч хэсгээс хийх боломжтой байна. Уурхайн нээлтэнд уул-техникийн хувьд хүндрэл гарахааргүй байгаа юм.

1.10 Зам харилцаа

“Мөнхсонор трейд” ХХК-ийн Зүүн элстэй нэртэй уурхайн лицензийн талбайд үүрэн холбооны бүх операторын сүлжээг ашиглах бүрэн боломжтой. Мөн тус уурхай нь төв замаас 2 км орчим зайд байрлах бөгөөд тээвэрлэлтийн ямар нэгэн асуудалгүй юм.

1.11 Дулаан хангамж

“Мөнхсонор трейд” ХХК-ийн Зүүн элстэйн элсний уурхай нь дулааны улиралд ажиллах бөгөөд ажилчдын хувьд байрлаж ажиллахгүй тул дулаан хангамжийн хэрэгцээ байхгүй.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

“Мөнхсонор трейд” ХХК нь 2024 онд элсний гарц муу байсан учир 7 хоногийн хугацаанд ажилласан бөгөөд ингэхдээ “Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн уурхайн ажилчид болон техник, тоног төхөөрөмжүүдийг авч ажиллуусан.

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийн хүснэгт

№	Хэрэгжүүлсэн ажил	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Усан орчинд үзүүлэх			
1	Зөөврийн усыг зориулалтын ус нөөцлөх саванд хуримтлуулах, ус алдагдахаас сэргийлэх.	200.0	Усыг зориулалтын саванд хуримтлуулж, нөөцөлж байсан. Зөөврийн ус нөөцлөх савны зураг оруулав.
2	Хатуу, шингэн хаягдлын цэгийг ойролцоо байгуулах, бохирыг тогтмол хугацаанд зөөвөрлөн соруулах, ариутгал хийлгэх	255.0	“Хаан хангай хөгжил” ХХК-тай бохир ус соруулж зайлуулах гэрээ байгуулсан бөгөөд ажиллах хугацаандаа үүсгэсэн бохир усыг гэрээний дагуу соруулж зайлуулсан. Бохир соруулах компанитай хийсэн гэрээ, төлбөрийн баримтыг хавсралтад хавсаргав.
3	Унд ахуйн усны шинжилгээ хийлгэх	ОХШХ-ийн зардалд орсон	“Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн худгаас усаа татаж хэрэглэсэн тул Их булгийн худгийн усны шинжилгээний хариуг хавсралтад хавсаргав.
Хөрсөнд үзүүлэх			
1	Тээврийн хэрэгслийг олон салаа зам гаргахгүйгээр тогтсон нэг маршрутаар явуулах	Үйл ажиллагааны зардлаар	Тээврийн хэрэгслийг тогтсон нэг замаар явуулж ажилласан.
2	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахгүй байх, хориглосон таних тэмдгүүдийг байршуулах	140.0	Тэмдэг, тэмдэглэгээг байршуулахаар зориулж худалдаж авсан баримтыг хавсралтад хавсаргав.
3	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	-	Уурхай 7 хоног ажилласан учир шатах тослох материал гараагүй.
4	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Үйл ажиллагааны зардлаар	Өнгөн хөрсийг хуулан авч MNS5916:2008 стандартын дагуу салхинд хийсэх, усанд автах зэргээс хамгаалан овоолго хийсэн..
5	Хог хаягдлыг ордын ойр орчимд ил задгай хаяхгүй байх	Үйл ажиллагааны зардлаар	Төлөвлөгөөний дагуу ажилласан.
Ургамлан нөмрөг			
1	Тээврийн хэрэгслийг тогтсон нэг маршрутын замаар явуулах, ургамлан нөмрөг талхагдахаас сэргийлэх.	Үйл ажиллагааны зардлаар	Замыг тэмдэгжүүлэн олон салаа зам гаргалгүй нэг маршрутаар тээврийн хэрэгслийг явуулсан.
Амьтан			

**“ЗҮҮН ЭЛСТЭЙ” ЭЛСНИЙ ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

1	Уурхайн ухашинд мал амьтан унаж бэртэхээс сэргийлэх	Үйл ажиллагааны зардлаар	7 хоног ажиллсан учир мал амьтан унаж бэртэхээр хэмжээний ухааш үүсээгүй .
	Ажилчид хууль бус ан агнуур хийхгүй байхад анхаарч ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Хууль бус ан агнуур хийхгүй байх тал дээр ажилчдад зааварчилгааг уурхайн ажил эхлэхийн өмнө тогтмол өгч ажилласан.
	Нийт	605.0	

Тэмдэг тэмдэглэгээ, хогийн савны баримт, бохир ус соруулах гэрээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн гэрээг хавсралтад хавсаргав.



Зураг 2. Уурхайн замын тэмдэгжүүлэлтийн зураг

Зураг 3. Уурхайн усны сав



2.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Төслийн ТЭЗҮ-д тусгасны дагуу ашиглалтын хугацаанд 23 дахь жил хүртэл техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй тул 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.

2.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. *Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл*

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон дүйцүүлэх	3000.0	Төлөвлөгөөт өртөгийн зардлыг хандивласан санхүүгийн баримтыг хавсралтад хавсаргав.

**“ЗҮҮН ЭЛСТЭЙ” ЭЛСНИЙ ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		нөхөн сэргээлтийн ажил хийнэ.		
	Нийт		3,000.0	

“Мөнхсонор трейд” ХХК нь Нийслэлийн Байгаль орчны газраас санал болгосны дагуу Сонгинохайрхан дүүргийн “Инчон мөрөөдлийн төгөлд” мод тарих ажилд 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланд тусгагдсан Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөт өртөгийн зардлыг хандивласан болно. Төлбөрийн баримтыг хавсралтад хавсаргав.

Хүснэгт 5. Мод тарьсан газрын солбицол

№	Өргөрөг	Уртраг
1	48°8'20.13"	106°38'42.26"
2	48°8'13.93"	106°39'11.62"
3	48°8'12.45"	106°39'10.40"
4	48°8'19.51"	106°38'41.67"



Мод тарьхад оролцсон ААН байгууллагууд

1. Цээцээ импекс ХХК 250ш
2. Цээцээ импекс ХХК 250ш
3. Цээцээ импекс ХХК 125ш
4. Мөнх сонор ХХК 250ш
5. Монгол алт МАК ХХК 1666ш
6. Батшил ХХК 166ш
7. Күнлүн ХХК 208ш
8. Наран Хан булаг ХХК 83ш

Нийт 2,998ш мод тарилаа.

Тайлан гаргасан



Нүри ХХК захирал Х.Лхагважав

Зураг 4. Нүри ХХК-ий тайлангийн зураг

2.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус ордын ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

2.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй.

“Мөнхсонор трейд” ХХК-ийн биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийг мөрдлөг болгон уурхай орчмын дурсгалт газрууд, өнгөрсөн

үеийн хүн төрөлхтний түүхийн дурсгалууд, биет бус соёлын өв болох бүжиг, хөгжим, уламжлалт ахуй зэрэг соёлын олон янзбайдлыг бий болгох гол хүчин зүйлсийг хадгалан үлдэх, хамгаалах чиглэлээр ажиллах ба энэ талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж жил бүрийн БОМТ-д тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

2.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. *Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл*

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйл ажиллагааны зардлаар	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж хяналт тавьж ажилласан.
2	Аваар устгах төлөвлөгөөг жил бүр батлуулж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	
3	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Үйл ажиллагааны зардлаар	Ажилласан хугацаандаа аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгсөн.
4	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	-	Уурхайд “Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн ажилчдыг авч ажиллуулсан. Их булаг-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
5	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	400.0	Гал унтраах хэрэгслүүд болон галын булан байрлуулсан. Галын булангийн зургийг хавсаргав.
6	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Үйл ажиллагааны зардлаар	Уурхай ажиллах 7 хоногийн хугацаанд хүчтэй салхи шуурга дэгдээгүй.
7	Ажиллагсдыг хөдөлмөр хамгаалах хувцас хэрэгслээр бүрэн хангах	1572.7	“Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн ажилчид ажилласан. “Их булаг”-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан. Санхүүжилт дээр нь хамтран ажилласан.
8	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, авуулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	“Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн ажилчид ажилласан. “Их булаг”-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
9	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч артай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны зардал	“Цээцээ импекс” ХХК-ийн “Их булаг”-ийн ажилчид ажилласан. “Их булаг”-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
	Нийт зардал	1972.7	



Зураг 5. Гал унтраах хэрэгслийн зураг



Зураг 6. Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалтын үеийн зураг

2.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. *Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний
гүйцэтгэл*

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Уурхайд зориулалтын ахуйн хог хаягдлын сав байрлуулах	100.0	Уурхайн хогхоны ойролцоо хогийн сав түр хугцаанд байршуулсан.
2	Хог хаягдлыг төвлөрсөн нэг цэгт төвлөрүүлж, хог хаягдлын цэгийг гадна орчинд тархаж, салхинд хийсэхээс сэргийлж хашаажуулах, хамгаалах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны зардлаар	7 хоног ажилласан тул хийгээгүй.
3	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг ангилан ялгах, хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах	Үйл ажиллагааны зардлаар	Ажилласан хугацаандаа хог хаягдлыг ангилан ялгаж дахивар авах цэгт тушаасан.
4	Хог хаягдлыг орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж, тухай бүрт тээвэрлүүлэх	-	7 хоног ажилласан тул гэрээ байгуулаагүй.
5	Уурхайгаас гарсан ашигласан шатах тослох материалын үлдэгдэл, аюултай хог хаягдлыг зориулалтын саванд хадгалах, хуримтлуулах, газрын гадаргад асгарч алдагдахаас сэргийлэх	-	7 хоног ажилласан тул тээврийн хэрэгслээс шатах тослох материал гараагүй.
6	Аюултай хог хаягдал, ашигласан шатах тослох материалын үлдэгдлийг аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	-	7 хоног ажилласан тул тээврийн хэрэгслээс шатах тослох материал гараагүй.
7	Уурхайд стандартын шаардлага хангасан бие засах газар бий болгох.	Үйл ажиллагааны зардлаар	Бие засах газрыг цооногтой байгуулсан боловч уурхайн үйл ажиллагаа зогссон учир дээрх хэсгийг авч хүн, амьтан унаж бэртэхээргүй аюулгүй болгон түр таглаж орхисон.
8	Бие засах газарт болон бохирын цооногт ариутгал халдваргүйжүүлэлт хийх	116.5	Уурхай ажиллаж байх хугацаандаа шингэн хог хаягдлыг 3 удаа соруулан зөөж, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Ариутгал халдваргүйжүүлэлтийн санхүүгийн баримтыг хавсралтад хавсаргав.
Нийт зардал		216.5	

2.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

“Зүүн элстэй” элсний ордыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлсны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Хүснэгт 8. *ОХШХ-ийн гүйцэтгэл*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
Агаар			
1	Агаарын тоосны шинжилгээ (TSP,PM10,PM2.5) мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO2, SO2, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	300.0	“Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар”-г дээж авч шинжилгээ хийлгүүлсэн. Төлбөрийн баримтыг хавсаргав.
Хөрс			
1	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, рН, давсжилт, чийгшилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Са, Mg, P2O5, K2O, хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн)	850.0	Хөрсний хими, механик бүрэлдэхүүний задлан шинжилгээг “Нарт ШУҮН консалтинг” ХХК-ий итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн. Шинжилгээний хариу болон төлбөрийн баримтыг хавсаргав.
2	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)		
Ус			
1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	-	“Цээцээ импекс”ХХК-ийн “Их булаг”-ийн худгаас зөөж хэрэглэсэн. “Их булаг”-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан. “Их булаг”-ийн усны шинжилгээний хариуг хавсаргав.
Нийт зардал		1150.0	

2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. *Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл*


№	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	2024 онд зарцуулсан зардал /мян.төг/	Биелэлт
1	Ажилчдад хөдөлмөр Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилладаг.
2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	-	“Цээцээ импекс”ХХК-ийн “Их булаг”-ийн ажилчид ажилласан. “Их булаг”-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.
3	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх	-	2020 онд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэсэн. Батлагдсан хянан баталгааны дүгнэлтийг хавсралтад оруулав.
Нийт зардал		Үйл ажиллагааны зардлаар	



Зураг 7. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангасан зураг



Зураг 8. Ажилчид эмчийн үзлэгт хамрагдаж байгаа үеийн зураг



Зураг 9. Ажилчдыг ХАБ-ын сургалтад хамруулсан үеийн зураг

2.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 10. *БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөөний гүйцэтгэл*

№	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулсан газар
1	Тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	11-р сард	Нийслэлийн байгаль орчны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	12-р сард	Нийслэлийн байгаль орчны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам

ДҮГНЭЛТ

Хүснэгт 11. БОМТ-ний хэрэгжилтийн нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Тухайн жилийн БОМТБ-ийн нийт зардал /мян.төг/, 2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	605.0
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	3000.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	216.5
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	1150.0
	Нийт	4971.5

“Мөнхсонор трейд” ХХК –ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордыг ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийн тайланг боловсруулан гаргалаа.

“Мөнхсонор трейд” ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг ажиллах хугацаандаа хэрэгжүүлэн ажилласан. Зүүн элстэйн уурхай нь 2024 онд элсний гарц муу байснаас үүдэн 7 хоногийн хугацаанд ажилласан боловч тухайн жилд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд зайлшгүй хийж хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг (Дүйцүүлэн хамгаалах ажил, орчны хяналт шинжилгээ, уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнөх бэлтгэл ажил г.м) хийж ажилласан болохыг дурдах нь зүйтэй болов уу.

“Зүүн элстэй” элсний ордын БОМТ-нд 2024 онд нийт 13.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч Зүүн элстэйн уурхай нь 7 хоног ажилласан тул тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардалд 4.5 сая төгрөг зарцуулж ажилласан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29–ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
2. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн элстэй” элсний ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
3. Монгол улсын засгийн газрын 2023 оны 02 сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Кадастрын лавлагаа
4. Нөөцийн тушаал, дүгнэлт
5. ТЭЗҮ-ийн тушаал, дүгнэлт
6. ЭБМЗ-ийн хурлын дүгнэлт
7. Ерөнхий үнэлгээний дүгнэлт
8. Уул уурхайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас
9. БОХ-3 маягт
10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд хийсэн ажил
11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажил
12. Удирдлага зохион байгуулалт
13. ОХШХ-ийн лабораторийн шинжилгээний хариу, санхүүгийн баримтууд



МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000103997

2015.07.01

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011558143

/ Улсын бүртгэлийн дугаар /

5981026

/ Регистрийн дугаар /

Мөнх сонор трейд

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2015.06.30

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Гадаад худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

7210

Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллгээны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

10.00

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 22-р хороо, зүүн наран 15, 1036 тоот, Утас1: 99685498, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

356

2020.08.20

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

*20045-5295722

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Голомт банк	Төгрөгийн	1415104122	Д.Лэхсо

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Дорждэрэм овогтой Мөнхтөр-г Захирал-р томилсныг бүртгэв.	2015.07.01	Д.Лэхсо
2	Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж, 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.04.14	М.Монголжин
3	Энхжаргал овогтой Гантуяа -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2017.04.14	М.Монголжин
4	Улаанбаатар, Чингэлтэй, 19-р хороо, , шадивлан 1, , 184 тоот, Утас1 89055431, Утас2 91915431, Факс хаягийг шинээр бүртгэв.	2017.04.14	М.Монголжин
5	7220 Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх 2016.05.04-2019.05.04/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2017.04.14	М.Монголжин

2020 ооо, 2-д ... асар Бүртгэлийн № ...
 Нийслэлийн Чингэлтэй дүүргийн
 төгрөгийн нотариатч Т.Долгосон би
 энэ хуудсарт үнэн зөвийг гэрчилэв.
 Үйлчилгээний хэлэвчд ... төгрөг хураав
 Нотариатч

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 18/М013

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн

Нийслэлийн Налайх дүүргийн

5 дугаар хорооны нутаг дэвсгэр Элстэй нэртэй

газарт орших 99.4 гектар талбайг хамарсан түгээмэл тархацтай ашигт малтмалын

ашиглалтын талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал

олборлохыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011558143 тоот гэрчилгээтэй

"Мөнх сонор трейд" ХХК -д энэхүү тусгай зөвшөөрлийг 2033.09.17

дуустал хугацаагаар олгов.


Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

2018 оны 09 сарын 10 өдөр
Улаанбаатар хот





ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

Тусгай
зөвшөөрлийн
дугаар 18/М013

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огноо, тамга
001	<ul style="list-style-type: none">Бүртгэв: 2018.09.17-нд олгосон, 2033.09.17-нд дуусах тусгай зөвшөөрөл олгохНЗД-ийн 2018.08.30-ны А/786 дугаар захирамжТусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлөв. Хугацаа 2018.09.17-2019.09.17 хүртэл	2018.09.17 НБОГ-ын дарга Э.Баттулга  1117147176 УОА0939 097049
002	• Тусгай зөвшөөрлийн 2 дахь жилийн төлбөр төлснийг тэмдэглэв. Хугацаа 2019.09.17-2020.09.17	2020.01.23 НБОГ-ын дарга Э.Баттулга  1117147176 УОА0939 097049
		
	2020.09.08	



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

Тусгай
зөвшөөрлийн
дугаар **18/М013**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001	• 2018.09.17-нд олгосон, 2033.09.17-нд дуусах • Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийн огноо. 2018.08.30	99.4	0	1	107° 30' 01.48"E	47° 46' 40.40"N
				2	107° 30' 01.48"E	47° 46' 47.86"N
				3	107° 30' 25.95"E	47° 46' 47.86"N
				4	107° 30' 25.95"E	47° 47' 01.68"N
				5	107° 31' 30.20"E	47° 47' 01.68"N
				6	107° 31' 30.20"E	47° 46' 40.40"N



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН



Кадастрын лавлагаа

Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-11000095
Талбайн нэр	Элстэй
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	99.65
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Мөнх сонор трейд
Аймаг, сум, сав газрын нэр	Улаанбаатар хот Налайх дүүрэг, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	



ТАНИХ ТЭМДЭГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

- Ашиглалтын
- Хайгуулын

Засаг захиргааны хил

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

Тусгай хамгаалалттай газар нутаг

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар

Хамгаалалтын бүсүүд

- Гол мөрний урсац бүрэлдэх эх
- Ойн сан бүхий газар

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

- Онцгой хамгаалалтын бүс
- Энгийн хамгаалалтын бүс


Ус хангамжийн эх үүсвэр

- Эрүүл ахуйн хориглолтын бүс
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
- Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

- Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 4/26

Улаанбаатар хот

Нөөц хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 3.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны ХХ-04-05 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших 16R079 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Зүүн элстэй” нэртэй элсний ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүснэгт №1-ийн дагуу хүлээн авсугай.

2. Хүлээн авсан элсний нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь “Зүүн элстэй” нэртэй элсний ордод 2016 онд явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг “Мөнх сонор трейд” ХХК /Э.Гантуяа/-д даалгасугай.

ДАРГА  Б.БААТАРЦОГТ



10 0272

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2017.03.30

Улаанбаатар хот

Дугаар: ХХ-04-05

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших 16/R079 тоот тусгай зөвшөөрлийн талбайн “Зүүн элстэй” нэртэй элсний ордод 2016 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн элстэй” нэртэй элсний ордод 2016 онд геологич Э.Доржготов, Т.Мөнгөнбаатар, Б.Буянхишиг нарын гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич Ш.Чулуунбаатар, С.Энхболд нарын боловсруулсан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоонд Монгол Улсын мэргэшсэн инженер, геологич Р.Энхсайханы хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, ДҮГНЭЛТ гаргав.

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн элстэй” нэртэй 99.6 га талбайн 16/R079 тоот тусгай зөвшөөрлийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016 оны 05 сарын 04-ний өдрийн А/340 тоот захирамжаар “Мөнх сонор трейд” ХХК-д олгосон байна.

Судалгааны талбай нь Улаанбаатар хотоос 60 км, Налайх дүүргийн төвөөс 15 км-ийн зайд Элстэйн голын хөндийн дагуу Туул голтой нийлж буй цутгалангийн орчмын 3-3.5 км өргөнтэй хөндийн зүүн урд захад байрлана.

2. “Мөнх сонор трейд” ХХК нь 2016 онд өөрийн хөрөнгөөр дээрхи талбайд хайгуулын ажил гүйцэтгэж, барилгын элсний бодитой (В) нөөцийг тогтоон, хайгуулын ажилд нийт 28.5 сая төгрөг зарцуулсан байна.

3. 1951 онд М.Г.Королев нар Төв аймгийн нутагт 1:200000 масштабын геологийн зураглалын ажил явуулж байсан бөгөөд 1977 онд А.С.Чернышевич, С. Алтангэрэл нар Элстэйн голын элсний ордод хайгуулын ажил хийж, элсний нөөцийг 1.4-4.6 м гүн хүртэл бодож баттай зэргээр 279.0 мян.м³, бодитой зэргээр 352.0 мян.м³, боломжтой зэргээр 150.0 мян.м³, нийт 781 мян.м³ гэж тогтоосон байна.

4. “Зүүн элстэй” орд нь геологийн тогтоцын хувьд дээд дөрөвдөгч, орчин үеийн салхины гаралтай хурдас, дунд дөрөвдөгч орчин үеийн болон аллюви-пролювийн түр зуурын урсгал усны гольдрол, сайрын хурдасд хамаарагдах ба орд нь цайвар шаргал өнгөтэй, кварц хээрийн жоншны найрлагатай нэг төрлийн элс, элсэнцэр, маш бага хэмжээний хайргархаг материалаас тогтоно.

6. 2016 онд явуулсан хайгуулын ажлаар 7 шугамын дагуу 132 тууш метр 33 шурф малтан, дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгсөн байна. Технологийн туршилт болон лабораторийн ажлыг Барилга архитектур корпорацийн лабораторит хийлгэжээ.

Топогеодезийн зураглалын ажлыг “Од сүрвэй” ХХК-иар гүйцэтгүүлсэн байна.

7. Зохиогчид Зүүн элстэйн ордод 6 блок үүсгэн, бодитой (В) зэргийн нөөцийг 1146130.0 м³ элс гэж тооцсон байна.

Шинжээч ордын элсний нөөцийг дахин тооцоолж, зохиогчийн хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн саналаар ордын нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж үзсэн.

8. Ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан тооцоогоор жилд дунджаар 100 мян.м³ элс олборлоход ордыг нийт 13 жилийн хугацаанд ашиглан, 16 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 11 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлаар 3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах ба 1м³ эцсийн бүтээгдэхүүний өөрийн өртөг нь 69809.7 төг/м³ гэж тооцсон байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хаалтын зардалд 88.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

9. Бүртгэгдсэн бодитой нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-ийг боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон ордыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Тайлан зохиогчдын илтгэл, тайлбар, шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

а. “Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Зүүн элстэй нэртэй элсний ордод 2016 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” /ордын нөөц 2017 оны 01 сарын 01-ний байдлаар/ дахь 16R079 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах геологийн нөөцийг бодитой (В) зэргээр 1146130.0 м³ элс гэж зохиогчийн тооцоолсон хувилбараар, хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

б. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан Зүүн элстэй ордын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Г.Золсайхан)-д зөвшөөрөх.

в. Энэхүү дүгнэлтийн 9 дүгээр заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Мөнх сонор трейд” ХХК-д анхааруулах.

